

**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН  
БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
 хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Д.Хаянхярваа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд заасан тэтгэврийн аль өндөр хэмжээтэйг буюу илүү таатай нөхцөлийг сонгох боломж олгох харилцааг зохицуулахаар тусгажээ.

Хуулийн төсөл батлагдсанаар 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр түүнээс хойш төрсөн даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн хэмжээ буурахаас сэргийлж, ахмад настны нийгмийн баталгааг хангах, тэдний амьдралын чанарыг сайжруулахад эерэг үр дагавар гарна гэж үзсэн байна.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр хуулийн төслийг Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлоготой хэрхэн уялдуулсан тухай, Тэтгэврийн даатгалын нэрийн дансаар болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар даатгуулагчийн авах тэтгэврийн хэмжээний тооцоолол, ялгаа, Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин 1996-2010 оны хооронд тэтгэвэрт гарсан цэргийн албан хаагч болон 2010 оноос хойш тэтгэвэр гарсан цэргийн албан хаагчдын тэтгэврийн зөрүүг арилгах талаар хэрхэн ажиллаж байгаа тухай асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Д.БАТЦОГТ**

